Залуу хүмүүст тохиолдох тархины харвалтын тархвар, шалтгаан, эрсдэлт хүчин зүйл:

Системт тойм судалгаа

Ц.Дэлгэрмаа[1], Б.Журамт[2], Г.Цагаанхүү[1]

[1]АШУҮИС, АУС, Мэдрэл судлалын тэнхим
[2]АШУҮИС, Био-АС, Анатомийн тэнхим
Цахим шуудан: tsagaankhuu@mnums.edu.mn, Утас: 99290330

Түлхүүр үг:
Тархины цус харвалт
Эпидемиологи
Этиологи
Эрсдэлт хүчин зүйлс
Насанд хүрэгчид

Товч утга:
Үндэслэл: Дэлхий дахины янз бүрийн бүс нутагт тархины харвалтын жилд гарах өвчлөлийн дундаж 100.000 хүн амд 100-336, нас баралт 36-136 түвшинд хэлбэлзэж байгаа бөгөөд Монголд жилийн шинэ өвчлөл 100.000-д 220, нас баралт 113 тохиолдож, харвалтын өвчлөлөөр дээгүүр байранд орж байна. **Зорилго:** Залуу насны хүмүүст тохиолдох тархины цус тасалдах харвалтын тархвар судлал, шалтгаан, эрсдэлийн хүчин зүйлийн талаарх хэвлэлийн эх сурвалжиийг шүүн нэгтгэж, системт тойм судалгаа хийх. **Арга, аргачлал:** Судалгааны эх сурвалжуудад Cochrane Library, Datebase, Medline, PubMed, Google Scholar, Web of Science зэрэг олон улсын платформд нийтлэгдсэн бүтээлүүдээс “Stroke”, “Definition”, “Epidemiology”, “Etiology”, “Risk factors”, “Young Adult”, “Ischemia”, “Hemorrhage”, “Silent stroke зэрэг түлхүүр үгээр хайлт хийж, цуглуулсан эх сурвалжуудаас холбогдох мэдээ баримт, өгөгдлийг сонгон авч тойм өгүүллийг боловсруулав. **Үр дүн:** ДЭМБ-ын MONICA төслийн тайланд харвалтын өвчлөл 16 орны 35-64 насны 100.000 хүнд эрэгтэйчүүдэд 101-285, эмэгтэйчүүдэд 47-198 бүртгэгдсэн ба АНУ-д 55-аас доош насны 100.000 хүнд 113.8, түүнээс тархины шигдээс 100.000-д 73.1 ногдож, 10 гаруй хувь нь 55-аас доош насныхан эзэлж байна. Монгол улсад харвалтаар өвчлөгсдийн 21-26%-ийг залуу насныхан эзэлж байгааг сүүлийн үед хийгдсэн судалгаагаар тогтоосон бол Өрнөдийн орнуудад энэ үзүүлэлт 10-13%-ийн түвшинд байна. Залуу насанд тохиох харвалтын уламжлалт шалтгаан, эрсдэлийн хүчин зүйлээс артерийн хипертензи 45-60%, тамхидал 40-60%, архидал 40-50%, зүрхний эмгэг 18-30%, дислипидеми 30%, диабет 13%, таргалалт 7-36%, эрсдэлийн өвөрмөц хүчин зүйлээс мигрень 10-35%, жирэмслэлтээс хамгаалах дааврын хэрэглээ 10-22%, васкулит 6-10%, цусны бүлэгнэлтийн эмгэг 2-10%, судасны хуулрал 6-40%-ийг тус тус эзэлж байна. Шалтгаан зүйн TOAST ангиллаар том судасны өвчин 16-17%, жижиг судасны бөглөрөл 14-15%, зүрхний эмболи 19-20%, бусад тодорхой шалтгаант дэд хэв 22-23%, тодорхой бус шалтгаант дэд хэв 26-27% гэсэн үзүүлэлтээр ялгарч байна. **Дүгнэлт:** Тархины харвалтын эпидемиологийн үзүүлэлт улс орны хөгжлийн түвшин, бүс нутгийн газарзүйн онцлог, амьдралын хэвмаяг, нас хүйсний хамаарлаар ихээхэн хэлбэлзэлтэй (харвалтын давтамж 100.000/134.9-336.3; нас баралт 100.000/36.7-136.7) байгаа бөгөөд түүний дотор Монгол улс тархины харвалтын давтамж, нас баралтын зэрэглэлээр өндөр үзүүлэлт бүхий орны тоонд хамаарч байна. Залуу насанд тохиолдох тархины шигдээс Өрнөдийн орнуудад 10-13%-ийг эзэлж байгаа бол манай орны хувьд энэ үзүүлэлт 21-26%-д хүрч, шалтгаан эрсдэлийн уламжлалт ба өдөрмөц хэд хэдэн хүчин зүйлээр нөхцөлдөх онцлогтой байна. Тархины харвалт залуужиж байгаа учир шалтгаан, эрсдэлийн хүчин зүйлийг нарийвчлан судалж, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйл-ажиллагааг эрчимтэй явуулах шаардлагатай байна.

Удиртгал: Тархины судасны өвчин дэлхий дахинд, түүний дотор манай орны эрүүл мэнд-нийгмийн нэн тулгамдсан асуудлын нэг бөгөөд энэ нь уг эмгэгийн хүн амын дундах өргөн тархалт, оюун ухаан, үйл-ажиллагааны чадварт нөлөөлөх уршиг үр дагавараар тайлбарлагдана. Тархины харвалтын эпидемиологийн олон улсын хэмжээний судалгааны дүнгээс үзэхэд 20-р зууны хоёрдугаар хагас, 21-р зууны эхэн үед тархины

харвалт хүн амын дунд өргөн дэлгэрч буй эмгэг гэдэг нь улам бүр нотлогдсоор байна.[1,3,7,9,11]

ДЭМБ-ын статистикийн мэдээгээр өнөө үед дэлхий дахинд жилд дунджаар 17 сая хүн тархины харвалтаар өвчилж буйгаас 6.5 сая нь эхний 30 хоногт нас барж, 10.5 сая нь амьд үлдэж буй хэдий ч, урт хугацаагаар хөдлөмөрийн чадвараа алдаж, хүн амын нас баралтын ерөнхий бүтэц дотор тархины харвалтын эзлэх хувь 2-р байранд орох болов.[1-6,8-11] Дэлхийн Мэдрэлийн Холбооны хэвлэлүүдэд (2010-2019) "Тархины харвалт дэлхийн хүн амын эрүүл мэнд, амь насанд заналхийлж буй даяарчлалын хэмжээний асуудал болж байна" хэмээн сэтгэл түгшин мэдээлж байна.[2,4,9,10]

Зорилго: Залуу насны хүмүүст тохиох тархины цус тасалдах харвалтын тархвар судлал, шалтгаан, эрсдэлийн хүчин зүйлийн талаарх хэвлэлийн эх сурвалжиийг шүүн нэгтгэж, системт тойм судалгаа хийх.

Арга, аргачлал: Судалгааны эх сурвалжуудад хайлт хийхдээ эрдмийн бүтээлийг сонгох шалгуурыг боловсруулан, Cochrane Library, Datebase, Medline, PubMed, Google Scholar, Web of Science зэрэг олон улсын платформд зөвхөн англи хэлээр нийтлэгдсэн бүтээлүүдээс "Stroke", "Definition", "Epidemiology", "Etiology", "Risk factors", "Young Adult", "Ischemia", "Hemorrhage", "Silent stroke", "Leukoaraiosis", "Patent foramen ovale", "Coronary artery disease", "Dissection", "Hereditary vascular disease" зэрэг түлхүүр үгээр хайлт хийж сонгов. Эхний шатанд бүтээлийг сэдвийн нэрээр (хураангуйгаар) хайж, давхардлыг арилган, сонгогдсон бүтээлийн эх текстийг олж судлан, сэдвийн уялдаа холбогдлыг үнэлэн, тойм өгүүлэлд орох бүтээлийг сонгож авав. Тойм судалгаанд оруулах (урьдчилан зэхсэн) шалгуурын дагуу цуглуулсан эх сурвалжуудаас холбогдох мэдээ баримт, өгөгдлийг сонгон, системт тоймын стандартын дагуу чанарын үнэлгээ хийж, судалгааны тойм өгүүллийг боловсруулав.

Харвалтын тодорхойлолт: Харвалт нь тархины судасны эмгэгийн сууринд тархинд цочмог шигдээс юм уу цус харвалт үүссэнээс мэдрэлийн үйл-ажиллагаа гэнэт алдагдах шинжээр илэрдэг ноцтой эмгэг юм. Хуучин тодорхойлолтоор мэдрэлийн үйл-ажиллагааны алдагдлын шинжүүд 24 цагаас илүү хугацаагаар хадгалагдахыг харвалт, харин үүссэн шинжүүд 24 цагийн дотор арилбал цус тасалдах дайрал хэмээн тодорхойлдог (богино хугацааны ишеми тархинд гэмтэл учруулахгүй) байсан үзэл баримтлал сүүлийн үеийн дүрслэлт шинжилгээний боловсронгуй техникийн тусламжтайгаар шинжтэмдгүүд хэдийгээр хурдан арилсан ч, шигдээсийн голомт үүсдэг болохыг нотлоод байна. Тиймээс цус тасалдах дайрал тохиосон өвчтөнд тархины эдийн үхжил ямар нэг хэмжээ, байрлалаар үүсэж, хөнгөн зэргийн харвалтад хүргэдэг байна.

Тархины цусан хангамж дутлын оношзүйн сүүлийн үеийн нотолгоонд тулгуурлан харвалтыг тодорхойлбол, гэнэт үүссэн шинжтэмдгүүд 24 цагаас илүү хугацаагаар үргэлжилсэн буюу тэдгээр шинжүүд 24 цагаас богино хугацаанд эргэж харьсан ч, дүрслэлт шинжилгээгээр тархины цочмог гэмтэц нотлогдсон тохиолдолд харвалт гэж үнэлнэ.[1]

Америкийн Мэдрэл Судлалын Академийн судлаачид тархины харвалтын тухай ДЭМБ-ын тодорхойлолт хуучирсан хэмээн мэдээлж, орчин үед тархины дүрст шинжилгээний мэдрэг аргууд гарч, морфологийн шинжилгээ, эмчилгээний шинэ аргууд хөгжиж байгаагийн үр дүнд харвалтын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, XXI зууны судалгаа шинжилгээ, эмнэлзүйн практикт хэрэглэх гарцаагүй шаардлага тулгарч буйг үндэслэн, харвалтын тодорхойлолтыг цаг хугацааны шалгуурт голлон суурилах бус тархины эдэд суурилсан тодорхойлолтыг дэвшүүлсэн байна.[1]

Харвалтын эпидемиологи: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) жил тутмын статистикийн мэдээгээр эдийн засгийн өндөр хөгжилтэй орнуудад хүн амын нас баралтын шалтгааны ерөнхий бүтэц дотор тархины харвалтын эзлэх хувь 2-р байранд орох болов. Өрнөдийн үйлдвэржсэн орнуудад жил тутам 1.000.000 хүн ам тутамд 2400 харвалт, 500 орчим цус тасалдах дайрлын тохиолдол гарч байгаагаас өвчтөний гуравны нэг нь нас барж, бараг тэн хагасаас илүү хувь нь хөдөлмөрийн чадвараа алдан, дөнгөж дөрөвний нэг нь бие даасан байдлаа сэргээж байна.[2-4] Чухам иймээс тархины судасны өвчний эмчилгээ, сэргийлгийн асуудал зөвхөн анагаах ухааны төдийгүй нийгэм-эдийн засгийн нэн чухал асуудал юм.

Харвалттай өвчтөнд үзүүлэх яаралтай тусламжийн бүх шатанд цаг хугацаа (амь нас, үйл-ажиллагааны сэргэлтэнд) шийдвэрлэх нөлөөтэй учир өнөөдөр дэлхийн харвалт судлалын төвүүд "Цаг хугацаа–тархи" гэсэн уриаг дэвшүүлж, тархины харвалтын оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх асуудалд шинэ чиглэл баримтлахыг зөвлөж байна. Харвалттай өвчтөний тусламж үйлчилгээнд өндөр мэдрэмж бүхий оношилгооны арга техник нэвтэрч байгаа ч, өртөг өндөр, эмчилгээний дэвшигдэж буй шинэ аргын сонголт нарийн, эсрэг заалт олон, үүний зэрэгцээ судсанд үүссэн бүлэнг (тромб) уусгах үр дүнтэй эмчилгээг сонгоход цаг хугацаанаас өрсөх шаардлага гарч байна. Орчин үед дэлхийн харвалт судлалын төвүүдэд мэдрэл, зүрх-судас, мэдрэлийн мэс засалч, сэхээний эмч, бэлтгэгдсэн сувилагч нар оролцсон мэргэжлийн баг ажиллаж, харвалттай өвчтөнд цаг алдахгүй эрчимт эмчилгээний тусламж үзүүлэх болсон нь бага хохиролтой давж, үйл-ажиллагааны гүнзгий алдагдалд хүргэхгүй өвчтөний эрүүл мэндийг сэргээх боломж бүрдэж байна.

Харвалтын өвчлөл (Incidence): Дэлхийн хөгжсөн ба хөгжиж буй улс орнуудад харвалтын жилийн гаралт 100.000 хүн амд 134.9-336.3, нас баралт 36.7-136.7 тохиолдлын хэлбэлзэлтэй бүртгэгдэж.[2,4] байгаа бол Монголд 100.000 хүн амд жилд гарах харвалтын давтамж 220, нас баралт 113 ногдож буй нь манай улс харвалтын өвчлөл, нас баралтаар дэлхийд дээгүүр түвшинд байгааг харуулж байна.[5] Харвалтын дараа

амьд үлдэгсдийн 50% нь хөдөлгөөн, мэдрэхүй, оюуны чадвахгүй болж, эрүүл мэнд, гэр бүл, санхүүгийн хүнд сорилттой тулгардаг. ДЭМБ-ын статистикийн сүүлийн үеийн мэдээгээр дэлхий дахинд жилд ойролцоогоор 15-17 сая хүн тархины харвалтад нэрвэгдэж байгаагаас 5 сая нь эхний 30 хоногт нас барж, амьд үлдэгсдийн 5 сая нь хөдлөмөрийн чадвараа алдаж, дөнгөж гуравны нэг хүрэхгүй хувь нь эрүүл мэндээ сэргээж байна.

Монгол улсад анх 2015-2018 онд залуу насанд тохиолдох харвалтын асуудлаар явуулсан судалгааны үр дүнгээр нийт харвалтын дотор "Залуу" харвалт 20-49 насанд 24%-ийг эзэлж, шалтгаанзүйн ангиллаар уламжлалт эрсдэлийн хүчин зүйлээс гадна судасны өвөрмөц хүчин зүйлээр нөхцөлдөн үүсэх дэд хэвийг тогтоож, жижиг артерийн бөглөрөл, том артерийн тромбоз, зүрхний гаралтай эмболи, өвөрмөц шалтгаант дэд хэв, шалтгаан тодорхойгүй дэд хэв тус бүрийн эзлэх давтамжийг статистик магадлалтай тооцоолон гаргаж, "Чимээгүй" шигдээс тархины харвалтын бие даасан хэлбэр болох тухай үзэл баримтлалыг дэвшүүлжээ.[5]

Харвалтын эпидемиологийн чиглэлээр Улаанбаатар хотын насанд хүрсэн хүн амын дунд 1970-аад оноос хойш хийгдсэн үечилсэн судалгааны дүнгээр 1998-1999 онд жилд гарах харвалтын өвчлөл 1000 хүн амд 2.97, нас баралтын түвшин 1.32 байсан нь 1970-аад оны үзүүлэлттэй харьцуулахад өвчлөл, нас баралтын түвшин, ялангуяа 50-иас дээш насанд 4-5 дахин өссөн дүн тодорхойлогджээ.[6] Харин 2019-2021 оны судалгаагаар шинэ харвалтын жилийн гаралт 100.000 хүн амд 156.1, нас баралтын кофициент 36.1% гарсан бөгөөд өвчлөлийн энэ үзүүлэлтийг 1998-1999 оны үзүүлэлттэй харьцуулахад 50-иас доош залуу насныхны дунд харвалтын гаралт ихсэх магадлал ажиглагдсан байна.[14] Эндээс үзэхэд сүүлийн арван жилд харвалтын ноошилгоо, эмчилгээний практикт орчин цагийн арга техник нэвтэрч байгаагийн үр дүнд энэ өвчин буурах хандлагатай байгаа ч, нөгөө талаас харвалт залуу насныхны дунд ихсэж буй нь амьдралын хэв маяг, хоол хүнс, архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөн дутал, таргалалт зэрэг эрсдэлийн хүчин зүйлтэй холбоотой байх магадлалтай.

Харвалтын тархалт (Prevalence): Харвалтын тархалт нь тухайн цаг үед харвалтаас амьд үлдэгсдийн тоог илэрхийлдэг. Дэлхийд дунджаар харвалтын тархалтын түвшин 100.000 хүн амд 500 гэж үзсэн статистикийн тооцоо бий.[2,8] Сүүлийн үеийн мэдээгээр АНУ-д харвалтад өртсөн 4 сая хүн амьдарч байгааг тэмдэглэжээ. Улс орнуудад явуулсан судалгааны дүнгээс үзэхэд харвалтын тархалтын түвшин 100.000 хүн амд тооцсоноор АНУ-ын Миннесота мужийн Рочестер хотод 556, Данийн Копенхагинд 406, Хятадад 719 байгааг тогтоосон байна.[2,3]

Австрал, Европ дахь харвалт судлалын байгууллагууд судалгааны дүндээ тулгуурлан нийт хүн амын 0.2%, 65-аас дээш насны хүн амын 1% жил бүр тархины харвалтаар шинээр өвчилдөг гэсэн математик магадлалын тооцоо хийсэн байна.[4] Энэ магадлалаар Монгол улсын 3 сая хүн амд тооцож үзвэл, 15-64 насныхан 68.8 хувь буюу 2 сая 64 мянга, үүнээс харвалтад өртөх нь 0.2 хувь буюу 4128; 65-аас дээш насныхан 3.8 хувь буюу 114.000, үүнээс харвалтад өртөх нь 1% буюу 1140, бүгд жил тутам шинээр 5268-6000 хүн харвалтад өртөх эрсдэлтэй болохыг тогтоосон байна.[5] Мөн үүнээс 2/3 нь амьд үлдэнэ гэж үзвэл Монголд 100.000 хүн амд ногдох тархалтын үзүүлэлт дунджаар 300-350 болохоор байна.

Атлантын орнуудад харвалттай өвчтөний оношилгоо, эмчилгээний зардалд жилд 40-100 тэрбум доллар зарцуулагдаж байгаа бөгөөд 80-аас дээш настны тоо өсөж буйтай уялдан, дараагийн 30 жилд энэ өртөг улам бүр өсөхөөр байгааг мэдээлж байна.[3] Харвалтын эрсдэлт хүчин зүйлийг эрт хянах, харвалтанд өртсөн тохиолдолд эмчилгээ-хяналтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх нь өвчтөний алдагдсан үйл-ажиллагааг сэргээх, дахин харвалтаас сэргийлэх үндсэн нөхцөл болно.

Залуу хүмүүст тохиолдох харвалтын давтамж: Залуу насныхны дунд тохиолдох харвалтын онцлогийн талаар хийсэн судалгааны мэдээлэл хомс ч, хэвлэлийн зарим нэгэн эх сурвалжаас авч үзэхэд, идэр залуу хүмүүсийн дунд гарах харвалтын давтамж 10-13%-ийн хэлбэлзэлтэй тохиолдож, улам бүр өсөх хандлагатай байна.[7-11, 18-20]

Дэлхийн 16 орныг хамруулсан ДЭМБ-MONICA төсөлт судалгаагаар 35-64 насны хүн амын дунд тархины харвалтын жилийн өвчлөл 100.000 эрэгтэй хүн амд 101-285, эмэгтэй хүн амд 47-198 тохиолдол бүртгэгджээ.[5,7,9] АНУ-д тархины харвалтын жилийн давтамж 55-аас доош насны 100.000 хүн амд 113.8, түүний дотор тархины шигдээс 100.000-д 73.1 буюу 10% үзүүлэлтэй гарсан байна.[8,9] Дэлхий дахинд харвалтаас учрах дарамтын гуравны хоёр нь хөгжиж буй орнуудад ноогдох ажээ.[9]

Монгол улсын хүн амын дундах өвчлөл, нас баралтын жил бүрийн статистик мэдээ баримтаас үзэхэд бүх харвалтын дотор залуу насныхан 20-26%-ийг эзэлж байгаа нь Өрнөдийн орнуудынхаас (10-13%) даруй 2 дахин өндөр үзүүлэлттэй байна.[16-18]

Залуу хүмүүст тохиолдох тархины цочмог харвалтын шалтгаан, эмгэгжам ахимаг насныхны харвалтаас харьцангуй ялгаатай, шинжилгээний явцад шалтгааны хүчин зүйл нь огт тогтоогдохгүй (40% хүртэл) өнгөрөх нь элбэг учир эмчилгээний үр дүн ч тавигдсан зорилгод хүрдэггүй болохыг цөөнгүй эрдэмтэд онцлон тэмдэглэсэн байна.[17-20]

Тархины харвалт залуужиж байгаагийн нотолгоо нь зүрх-судасны тогтолцооны эмгэгийн давтамж ихтэй бүс нутагт хийсэн судалгааны үр дүнгээр 45 хүртэлх насны залуу хүмүүс харвалтын тохиолдлын 30 гаруй хувийг бүрдүүлж байгаа бөгөөд өвчлөгсдийн ихэнх хувь нь идэр насны эрэгтэйчүүдэд ноогдож, өвчний түүхийн баримтаар эрт эхлэх артерийн хипертензи, атеросклероз, архидал, тамхидал, мансуурах дон (наркомани), сэтгэлийн дарамт (стресс) зэрэг эрсдэлт хүчин зүйлс зонхилох шалтгаан болж байна.[20-23]

Монгол улсад хөдөлмөрийн насны хүмүүсийн дунд тархины харвалтаар өвчлөл, нас баралт сүүлийн 20 жилд 30%-иар нэмэгдэж, цаашид ч улам өсөх төлөвтэй байгаа юм.[6,16-17]

Дэлхий дахинд тархины судасны өвчнийг үүсгэгч эрсдэлийн хүчин зүйл хэлбэрэлтгүй өсөж буйтай холбогдон харвалтын тархалтын давтамж, ялангуяа хөгжиж буй орнуудад жилээс жилд улам бүр нэмэгдэх боллоо.

Тархины харвалт хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын голлох хүчин зүйл болсоор байгаа бөгөөд харвалттай өвчтөний 31%-д бусдын тусламж шаардлагатай, 20% нь явах чадвараа алддаг, дөнгөж 8% нь эрхэлж байсан ажлаа гүйцэтгэх чадамжтай болдог.[8,9,11]

Хөгжилтэй орны хүн амын дундах харвалтын 80%-ийг шигдээс харвалт эзэлж байгаа бөгөөд түүний 10-аас доошгүй хувь нь залуу насныханд ноогдож байна.[10-12, 22-29]

“Залуу” насанд хүрэгчийн харвалт гэдэг нь 45 юм уу 50 хүртэлх насанд тохиолдох тархины харвалтыг хэлэх бөгөөд идэр залуу насны хүмүүсийн амьдралын хугацааг богиносгон, нийгэм-эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг эмгэг юм. “Залуу” харвалтын талаар явуулсан 2000-аад оноос өмнөх судалгааны эх сурвалжаас харахад насны дээд хязгаарыг 40-45 насаар[13] авч байсан бол сүүлийн үеийн болон одоо явагдаж буй судалгаанд 50 хүртэлх нас юм уу бүр 55 хүртэлх насыг (www.sifap.de) насны дээд хязгаараар авч байгаа нь хөгжсөн орнуудын хүн амын наслалт уртсаж байгаатай холбоотой.[34-40]

Сүүлийн хориод жилийн хэвлэлийн тоймоос үзэхэд үйлдвэржсэн оронд тархины шигдээс харвалт 100.000 хүн амд 101-264 хүртэл тохиолдол бүртгэгдсэн байна.[9,11,24] Залуу хүмүүст тохиолдох тархины харвалтын талаар 1940-1950-иад оны үед цөөн тооны эмнэлзүйн ажиглалтын тохиолдолд тулгуурласан хэвлэлийн анхны мэдээлэл гарч байсан бол сүүлийн хоёр арван жилийн турш “Залуу” харвалтын жилд гарах тохиолдлын давтамж улам бүр өсөж байгаа нь харвалтын оношилгооны арга сайжирч ирсний үр дүн мөн гэж судлаачид онцлон тэмдэглэсэн байна.[24-27]

Залуу хүмүүст тохиох ишеми харвалтын шинэ өвчлөл (Incidence): Тархины цус тасалдах харвалтын шинэ өвчлөл буюу жилийн гаралтын давтамж хүн амзүйн угсаа гарал, газарзүйн хүчин зүйл, судалгааны сонгосон аргаас хамаарна. Тархины харвалтын шинэ тохиолдлыг судлахдаа ДЭМБ-аас гаргасан харвалтын стандарт тодорхойлолтын дагуу проспектив юм уу хүн амд суурилсан аргаар гүйцэтгэх шаардлагатай.[9,30] Финляндад хүн амд суурилсан гурван томоохон судалгаагаар харвалтын шинэ тохиолдол 100.000-д 359 бүртгэгдэж, насны хамаарлаар цаг хугацаа өнгөрөхийн хэрээр 100.000-д 100 хүртэл буурах хандлага ажиглагдаж, бүс нутгийн хувьд ихээхэн хэлбэлзлэлтэй байжээ.[20] Тархины харвалт залуу насанд Итал улсын[34] хүн амд суурилсан судалгаагаар (<45 насанд) бүх шинэ харвалтын 2%, Германд[19] эмнэлэгт суурилсан судалгаагаар шигдээс харвалтын 6%, Шведэд[38] харвалтын хоёр том төвд хийсэн судалгаагаар тархины шигдээсийн (16-45 насанд) 11%, Монголд[37] эмнэлэгт суурилсан судалгаагаар тархины шигдээс 21.1%-ийг эзэлсэн үзүүлэлт тодорхойлогджээ.

Залуу хүмүүст тохиолдох цус тасалдах харвалтын чиглэлээр хамгийн сүүлийн үед явуулж буй судалгаанд насны дээд хязгаарыг 49-ээр тогтоож, Өрнөд Европын орнууд, АНУ-д явуулсан судалгаагаар тархины шигдээсийн давтамж 100.000-д 5.8-11.4 хүрснийг мэдээлж байна.[9,19,26-30] Судалгааны үзүүлэлтээс нас, хүйсний хувьд “Залуу” харвалтын давтамж эрэгтэйчүүдэд давамгайлж, харин эмэгтэйчүүд 35-аас доош насанд илүүтэй өртөх хандлага ажиглагдаж байна.[21,22,26,37,43] “Залуу” харвалтын өвчлөлд хүн амын яс угсааны ялгаа ч байгаа бөгөөд Хойд Манхаттаны[40] судалгаа болон Балтимор-Вашингтоны[26] харвалтын хамтарсан судалгаагаар африк гаралтай залуу америкчуудад цагаан арьстныг бодоход харвалт 2 дахин илүү тохиолдож буйг тэмдэглэжээ.

Залуу хүмүүст тохиолдох тархины цочмог шигдээсийн явц харьцангуй хөнгөн, нас баралтын давтамж цөөн байдаг тухай хэвлэлийн эх сурвалжид тэмдэглэжээ.[27,28,31,39,86,88]. “Залуу” харвалтын үеийн нас баралтын давтамж 30 хоногийн дараа 2.3%-3.4%[31,39], эхний жилд 4.5%-6.3%[27-28] хүрдэг хэдий ч, өвчтөний насны дээд хязгаарыг хэдээр тогтоосноос хамаарч хэлбэлзэлтэй үзүүлэлт нийтлэгдэж буйг үгүйсгэхгүй. Гэвч үхлийн хувь эмчилгээ-хяналтын явцад эрс буурч, 0.8%-1.8%-д хүрдэг ажээ.[27-28] Монголд хийсэн судалгааны үзүүлэлтээр хагас жилийн доторх нас баралт судалгааны 20-49 насны бүлэгт 7.3%, 50-79 насны хяналтын бүлэгт 13.1%-д хүрсэн нь харвалтын дахилттай холбоотой байв.[37] Энэ судалгааны дүнгээр нас баралт 50-иас дээш насанд өндөр үзүүлэлтэй байгаа бол Финлянд улсад явуулсан судалгаагаар 45-аас дээш насанд,[21] өөр хоёр улсад хийсэн судалгаагаар 35-аас дээш насанд[30] нас баралтын тохиолдол нэмэгдэж буйг мэдээлсэн байна.

Залуу хүмүүст тохиох ишеми харвалтын шалтгаан, эрсдэлт хүчин зүйл: Залуу насанд тохиох тархины харвалтын эрсдэлт хүчин зүйл ахимаг насныхнаас багагүй ялгаатай тухай сүүлийн хоёр арван жилд хуримтлагдсан судалгааны мэдээлэл харуулсаар байна. Шигдээс харвалтын үл залруулагдах эрсдэлт хүчин зүйлд нас ахих, эрэгтэй хүйс, угсаа гарлын ялгаа, жин багатай төрөх, гэр бүлийн харвалтын түүх зэрэг хүчин зүйл хамаарна.[27,30] Тархины шигдээсийн сайтар нотолгоожсан, залруулагдаж болох эрсдэлт хүчин зүйлд зүрх-судасны өвчин (титэм судасны эмгэг, зүрхний дутагдал, захын судасны эмгэг), артерийн хипертензи, тамхидал, чихрийн шижин, гүрээний дотор артерийн шинж тэмдэггүй нарийсал, хавхлагын бус тосгуурын жирвэгэнээ, хадуур-эст өвчин, нийт липопротеид ба бага нягтралт липопротеид (БНЛП) болон холестеролын хэмжээ өндөр, их нягтралт липопротеидийн (ИНЛП) хэмжээ бага, хүнсний зохисгүй хэрэглээ (давсны хэрэглээ их, калийн хэрэглээ бага), таргалалт, хөдөлгөөн идэвхгүй байх, сарын тэмдгийн мөчлөг зогссоны дараах даавар нөхөх эмчилгээ зэрэг хүчин зүйл орно.[40] Бусад олон хүчин зүйл тогтоогдсон боловч тэдгээрийн холбогдол тодорхой бус байгаа нь бага нотолгоожсон хүчин зүйл хэмээн нэрлэх болжээ.[42-43] Эдгээр хүчин зүйлийн дотроос чухалд тооцогдох нь бодисын солилцооны хамшинж[53-54], архины хэт хэрэглээ[36,52], эмийн

хордлого[53], төрөлхийн ба олдмол хиперкоагулопати[59], жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл[41,61], үрэвслийн процесс[62-63], угтвар халдвар[63], дохиот ба дохиот бус мигрень[38,64,68,77-79], липопротеин(а)-ы түвшин өндөр байх[65], нойронд амьсгал тасалдах[66], нээлттэй зууван цонх[67], ургийн цусны эргэлтийн дутагдал зэрэг болно.

Австрал улсад 15-55 насны өвчтөний тохиолдлыг хөршүүдтэй нь нас, хүйсээр ижилсгэн хяналтын бүлгээр авч тархины шигдээсийн эрсдэлт хүчин зүйлийг харьцуулан судлахад хипертензи (OR 6.2, 95% CI 3.3-13.9), зүрхний эмгэг (OR 2.7, 95% CI 1.1-6.4), чихрийн шижин (OR 11.6, 95% CI 1.2-115.2), тамхидал (OR 2.5, 95% CI 1.3-5.0), олон жилийн (өдөрт 60 г-аас их) архидал (OR 15.3, 95% CI 1.0-232.0) зэрэг нь энэ насны бүлэгт харвалтын гол эрсдэл болох нь тэмдэглэгджээ.[57] Саявтархан Норвег улсад харвалтын дараа амьд үлдэгсэд болон хяналтын бүлэгт эрсдэлийн хүчин зүйлийг шуудангаар явуулсан асуумжаар судлахад хипертензи (OR 2.4, 95% CI 1.5-4.0), өмнөх зүрхний шигдээс (OR 2.8, 95% CI 1.1-7.4), тамхидал (өдөрт 15 ш-ээс олон, OR 3.8, 95% CI 2.1-6.8) олон хувьсуурт дүн шинжилгээгээр харвалтын гол эрсдэл болох нь тогтоогдсон байна.[68]

Монгол улсад цус тасалдах харвалттай 20-49 насны 130 тохиолдолд хийсэн судалгаагаар тархины шигдээс үүсэхэд эрсдэлт хүчин зүйлсийн үзүүлэх нөлөөг $Хи^2$ сорилоор тооцож үзэхэд, залуу насны бүлэгт артерийн хипертензи (OR 0.19; 95% CI 0.10-0.33, <0.001), тамхидал (OR 1.97; 95% CI 1.17-3.31, p=0.013), архидал (OR 7.38; 95% CI 3.88-14.05, p<0.001), зүрхний эмгэг (OR 0.66; 95% CI 0.36-1.20), дохиот мигрень (эмэгтэйчүүдэд OR 2.86; 95% CI 1.32-6.17, p=0.009), халдварын васкулопати (OR 18.81; 95% CI 2.43-145.53, p<0.001) статистикийн үнэн магадтай нөлөөг үзүүлж байсан бол хяналтын бүлгийн 50-79 насны 110 өвчтөнд артерийн хипертензи (OR 5.22; 95% CI 2.97-9.16, p<0.001), атеросклероз (OR 4.93; 95% CI 2.84-8.55, p<0.001), чихрийн шижин (OR 4.29; 95% CI 1.96-9.40, p<0.001) өндөр магадлалтай эрсдэл болох нь тогтоогдсон байна.[37] Финлянд улсад тархины шигдээс бүхий 16-60 насны 506 өвчтөнийг хамруулсан судалгаагаар эрэгтэйчүүдэд хипертензи, зүрхний эмгэг, тамхидал, чихрийн шижин; эмэгтэйчүүдэд мигрень, жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл, тамхидал зэрэг нь шигдээс харвалтын бие даасан эрсдэлт хүчин зүйл болох нь тогтоогджээ.[69] Энэ судалгаагаар 40 г-аас их архийг харвалт болохоос 24 цагийн өмнө хэрэглэсэн эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсэнд (эрэгтэйчүүд 24ц/41-120г уусан бол RR 3.7, 95% CI 1.9-8.1, 24ц/120г-аас илүү бол RR 7.6, 95% CI 2.0-29.1; эмэгтэйчүүд 24ц/40г-аас илүү уусан бол RR 5.7, 95% CI 1.8-18.5) ноцтой эрсдэл учруулж буйг мэдээлжээ. Судлаачид тархины шигдээсийн эрсдэлт хүчин зүйлийг 15-49 насны эмэгтэйчүүдэд тохиолдол-хяналтын аргаар судлахад зүрхний өвчин, архины хэтрүүлсэн хэрэглээ, чихрийн шижин, хипертензи, мигрень, жирэмслэлтээс сэргийлэх хавсарсан бэлдмэлийг хэрэглэх нь харвалтын эрсдэлийг ихэсгэж буйг тэмдэглэсэн байна[37,41]. Эдгээр судалгааны дүнгээр урд нь үүссэн венийн тромбоэмболи харвалтын эрсдэлтэй шууд холбоотой байсныг бүлэгнэлтийн өөрчлөлтийг илтгэх үзүүлэлт гэж үзжээ.

Өмнөд Энэтхэгт тархины цочмог шигдээстэй 15-49 насны 214 өвчтөнийг сонгон, эмнэлэгт хэвтсэн бүлгийг (99 өвчтөн), хүн амд суурилсан (96 өвчтөн) хяналтын бүлэгтэй нас, хүйсээр харьцуулан судлахад тамхидал, артерийн систолын даралт өндөр байх, өлөн үеийн глюкозын хэмжээ их, ИНЛП-ын түвшин буурсан байх нь (OR 0.2, 95% CI 0.1-0.3) олон хувьсуурт статстикийн дүн шинжилгээгээр шигдээс харвалттай холбоотой болох нь тогтоогдсон байна.[70]

Бодисын солицооны 3 ба түүнээс илүү бүрдэл бүхий хамшинжтэй тохиолдлыг харьцуулахад хүн амд суурилсан бүлэгт ч (OR 4.8, CI 95% 1.9-11.8), эмнэлэгт хэвтсэн бүлэгт ч (OR 2.1, 95% CI 1.1-4.1) шигдээс харвалттай хүчтэй холбоотой байжээ.[70]

Франц улсад тархины цочмог шигдээстэй залуу насны 94 өвчтөнд хийсэн судалгааны дүнгээр эрэгтэйчүүдэд холестролын (БНЛП) түвшин өндөр байх (OR 3-15; 95% CI 1.2-8.1), артерийн хипертензи, тамхидал; эмэгтэйчүүдэд мигрень, жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл хавсран хэрэглэх нь (OR 7.3, 95% CI 1.8-29.9) харвалтын бие даасан эрсдэлт хүчин зүйл болно гэж үзжээ.[71].

Сүүлийн 40 жилд явуулсан урт хугацааны хяналтат, проспектив, мета-анализын судалгааны үр дүнгээс үзэхэд, липопротеин(а)-ы концентраци их байх нь тархины шигдээсийн хүчин зүйлтэй (RR 1.10; CI 1.02-1.18) холбоотой, гэхдээ ердийн липопротеин(а)-ы концентраци 3-5 дахин их байх нь нөлөө бүхий хүчин зүйл болдог байна.[62] Зарим судлаачид залуу хүмүүст үүсэх тархины шигдээсийн эрсдэлт хүчин зүйлтэй липопротеин(а) холбоотой болохыг тогтоосон хэдий ч,[65] нөгөө хэсэг судлаачид судалгааныхаа үр дүнг үндэслэн шууд холбоо байхгүй[70-75] хэмээн үзсэн бол зарим нэг нь зөвхөн эрэгтэйчүүдэд хамаатай[76] байх талаар тэмдэглэсэн нь маргаантай хэвээр байна.

Нидерландад хийсэн сүүлийн үеийн судалгааны дүнгээр (Urbanus et al) 18-49 насны эмэгтэйчүүдэд зүрхний шигдээс, тархины ишемит харвалт тохиолдох нь антифосфолипид эсрэгбиетэй холбоотой хэмээн үнэлжээ.[56]. Энэ судалгаагаар 1990-1995 онд тархины шигдээсийн учир эмнэлэгт хэвтсэн 175 өвчтөн, зүрхний шигдээстэй 203 өвчтөн, эрүүл 628 хүнийг асуумжийн аргаар судлах зорилгоор 1995 ба 2001 онд антифосфолипид эсрэгбиеийн хэмжээг лабораторид шинжлэхэд чонон яршлын антикоагулянт илэрсэн эмэгтэйчүүдэд (харвалттай өвчтөнд 17.2%, хяналтын бүлэгт 0.7%) эрсдэлийн харьцаа – OR 43.1 (95% CI 12.2-152) гарсан бол анти- β2- глюкопротеин I IgG илэрсэн эмэгтэйчүүдэд OR 2.3 (95% CI 1.4-3.7) гэсэн үзүүлэлттэй гарчээ. Харин антикардиолипин эсрэгбие IgG болон антипротромбин эсрэгбие IgG тархины шигдээстэй өвчтөнд олдоогүй учир эдгээр эсрэгбие нь харвалттай холбоогүй гэж үзжээ.

Залуу хүмүүст тохиолдох тархины шигдээсийн эмгэгжамын асуудалд ганц эрсдэлт хүчин зүйлийг тооцох нь учир дутагдалтай бөгөөд харин хавсарсан хүчин зүйл үлэмжийн нөлөөтэй. Тохиолдол-хяналтын судалгааны үр дүнгээс үзэхэд, мигрень бүхий залуу эмэгтэйчүүдэд тархины шигдээс үүсэх харьцангуй эрсдэл (RR) 3 дахин нэмэгдэнэ, дохиот мигрений

үед эрсдэл улам ихсэнэ (RR 3.8-6.2)[77],тамхи татдаг бол эрсдэл 3 дахин өснө (OR 10.0)[78], жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл хэрэглэвэл 4 дахин нэмэгдэнэ (OR 13.9-16.9)[77-78]. Ер нь мигрень, жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл, тамхидал гурвуул хавсарвал харвалтын эрсдэл үлэмж хүчтэй нэмэгддэг (OR 34-35) тухай мэдээлсэн байна.

